

~ Японы талаар илүү сайн мэдэж авцгаая ~

Мангагаар дамжуулан мэдэж авцгаая

鏡開き (Кагами бираки)



鏡開き нь 松の内 (мацуно-үчи/хаалганд нарсан чимэг зүүх үе) (улс даяар 1/1-1/7, нутаг бүр харилцан адилгүй) дууссаны дараа 1/11-нд 鏡餅 (кагами-мочи)-г хагалж иддэг заншил. Бурхан залардаг гэгддэг 鏡餅 (кагами-мочи)-г дэлгэснээр, 年神様 (тошигами-сама/оны бурхан)-г үдэж гарган, шинэ жилдээ зааг тогтоодог. Бурхан заларсан байсан お餅 (мочи будаа)-г идэж, тэр жилдээ өвчин тусахгүй, эрүүл өнгөрүүлэх хүч хүртдэг гэгддэг.

“とも/Томо” нь, Японд амьдрахад хэрэг болох мэдээлэл, Япон хэл сурахад хэрэг болох зүйлс зэргийг, дуудлагыг нь хадсан Япон хэл болон гадаадын 9 орны хэл (Вьетнам, Хятад, Филиппин, Индонези, Тайланд, Камбодж, Мьянмар, Монгол, Англи) дээр гаргадаг. Япон хэл дээрх хувилбарыг товхимол хэлбэрээр хүргэдэг ба гадаад хэл дээрх хувилбарыг JITCO-гийн цахим хуудаснаас ухаалаг утас зэргийг ашиглан, PDF хэлбэрээр харах боломжтой. Та бүхэнд орж харахыг санал болгож байна. (<https://www.jitco.or.jp/ja/tomo/>)



“Зохион бичлэг бичсэн нь, өөрөө өөрийнхөө талаар эргэцүүлэн бодох боломж болсон.”

“Ур чадварын дадлагажигч гадаад иргэд, сургалтанд хамрагдагчдын Япон хэлний зохион бичлэгийн 32-р уралдаан”-ы тэргүүн байрын шагналыг хүртсэн TRAN THUY AN сан

実習実施者：株式会社ツクイ 監理団体：協同組合企業交流センター



JITCO-гоос зохион байгуулсан Япон хэлний зохион бичлэгийн уралдаанаас тэргүүн байрын шагналыг хүртсэн, Вьетнамаас ирсэн ур чадварын дадлагажигч TRAN THUY AN сан. Тэрбээр Японд ирээд жил хагас орчим болж байгаа ба одоо Токио хотод асрамжийн байгууламжид дадлага хийж байгаа. 1-р сарын дугаараар, зохион бичлэгийн уралдаанд оролцсон шалтгаан болон зохион бичлэгийн талаарх бодол, Япон хэл суралцах тухай гэх мэт зүйлсийн талаар асууж ярилцлаа.

— **Зохион бичлэгийнхээ сэдвийг яаж сонгосон бэ? Мөн, зохион бичлэг бичих явцад ямар бэрхшээл тулгарсан бэ?**



Төв компаний хүн надад “Япон хэлээр зохион бичлэг бичиж үзээч.” гэж хэлэхэд, өөртөө итгэх итгэл байхгүй байсан болохоор эхэндээ татгалзсан боловч, ахмад дадлагажигч нарын бичсэн зохион бичлэгийг уншаад, бас төв компаний хүнтэй ярилцаж байхдаа ердийн үед бараг анхаарч үзэж байгаагүй зүйл зохион бичлэгийн сэдэв байж болохыг анзаарсан. Тэгээд бага багаар юу бичихийг хүсч байгаа тухай төсөөлөлтэй болж ирэн, “Мэндчилгээ” сэдэвтэй зохион бичлэг бичихээр шийдсэн. Япон хэлээр олон өгүүлбэр бичих нь анхны удаа байсан тул маш өндөр даваа байсан. Эхлээд Вьетнам хэлээр сэдэвтэйгээ хамааралтай үйл явдал болон мэдэрсэн зүйлсээ бичиж, ерөнхий хэлбэрийг нь бий болгосныхоо дараа Япон хэл рүү

буулгасан. Бичье гэж шийдсэнээс хойш 1 сар гаруй хугацаа зарцуулан бичиж дуусгасан.

— **Япон хэл суралцахад хэцүү санагддаг зүйл юу вэ? Мөн, суралцах явцад мэдэрдэг зүйлээсээ ярьж өгөөч.**

Япон хэлний хамгийн хэцүү санагддаг юм нь “дуудлага”. Вьетнам хэлэнд байхгүй дуудлага болон буруу цээжилчихсэн үгийг засахад бэрхшээлтэй байдаг. Мөн, бичих тухайд, асрамжийн мэргэжлийн үг хэллэгээр тайлан бичиг бичих нь эхэндээ хэцүү байсан боловч бага багаар дасч ирээд, одоо бол хурдан бичиж чаддаг болсон. 7-р сарын JLPT-гийн N2-т тэнцэхийн тулд Япон хэлний түвшнээ улам дээшлүүлэе гэж бодож байгаа. Компаний сургалтаар Япон хүнтэй групп ажлын үеэр ярилцах, гэрийн даалгавраа хийх гэх мэтээр өдөр тутамд туйлбартай шамдах нь чухал гэж санагдаж байна.

— **Ажил хийх явцад урам мэдэрдэг ямар зүйл байдэг вэ? Мөн, баярласан үйл явдлаа бидэнтэй хуваалцаач.**

Маш жижиг зүйл хэдий ч, настай хүнд ямар нэг юм хийж өгөх нь миний хамгийн том аз жаргал. Ажил бол

өдөр бүр завгүй, их хэцүү ч, үйлчлүүлэгч маань миний нэрийг санаж байсан үед маш их баярлаж, урамтай байдаг.

— **Цаашид зохион бичлэг бичиж үзье гэж бодож байгаа уншигчдад хандаж юу хэлэх вэ?**

Зохион бичлэг бичих нь Япон хэлний дасгал болох нь тодорхой хэдий ч, би “бичсэн нь сайн болж” гэж бодсон нь, өөрөө өөрийнхөө талаар эргэцүүлэн бодох боломж болсон гэж мэдэрсэн явдал юм. Ердийн үед мэдэрдэг зүйлийнхээ талаар гүнзгийрүүлэн эргэцүүлж чадсан нь миний цаашдын ажлын хувьд том утга агуулсан зүйл байсан. Зохион бичлэг бичих нь маш хэцүү сорилт хэдий ч, бичиж дуусгавал шинэ өөрийгөө олж харна гэж бодож байна. Хэрэг болгож Японд ирсэн юм чинь өөрийнхөө потенциалд итгэж, зохион бичлэг бичихэд өөрийгөө сорьж үзээрэй.



JITCO нь, цаашид ч Япон хэлний зохион бичлэгийн уралдаан зохион байгуулахаар төлөвлөх болно. Уралдаан зарлах талаар тодорхой шийдмэгцээ JITCO-гийн вебсайтаар мэдээлэхээр товлож байна. Та бүхнийг оролцохыг урьж байна.

“Япон хэлний зохион бичлэгийн уралдааны шилдэг бүтээлийн цомог 2024”-ийг JITCO-гийн HP-ээс харах боломжтой.

<https://www.jitco.or.jp/ja/service/competition.html>



Цаасан мөнгөн тэмдэгтийн талаарх бяцхан мэдлэг

Сайтар
ажиглаж
үзэцгээе!



Японд 2024 оны 7-р сард, 20 орчим жилийн дараа цаасан мөнгөн тэмдэгтийн загвар шинэчлэгдэж, хуурамчаар үйлдвэрлэхэд илүү бэрх, ялгахад илүү хялбар болж шинээр гарсан. Шинэ цаасан мөнгөн тэмдэгтийн хөрөг зураг (нүүр)-т Японы орчин үежилтэд хувь нэмэр оруулсан 3 хүн зурагдсан байна. Тэгвэл, цаасан мөнгөн тэмдэгтэд зурагдах хүнийг яаж шийддэг юм бол? Хуулиар заасан зүйл байхгүй хэдий ч,

- Аль болох бодит хүн бөгөөд ажлын

амжилттай, олонд өргөнөөр танигдсан, дотно санагддаг гэх мэт иргэдийн хүндлэл хүлээсэн, Японыг төлөөлөх хүн байх

- Хуурамчаар үйлдвэрлэхээс сэргийлэх гэсэн утгаараа, амархан хуулбарлах боломжгүй бөгөөд хүний нүд татах онцлог бүхий царайтай байх гэх зэрэг шалтгаанаар сонгогддог.

Шинэ цаасан мөнгөн тэмдэгт болж өөрчлөгдсөн ч, өнөөг хүртэлх цаасан мөнгөн тэмдэгт ч нэг хэсэгтээ энэ хэвээрээ хэрэглэх боломжтой тул,

“Өнөөг хүртэлх цаасан мөнгөн тэмдэгт хэрэглэх боломжгүй болно.” гэх мэт буруу ташаа мэдээлэл болон залилан мэхлэх үйлдэл зэрэгт сайн анхаараарай.

Бид ердийн үед цаасан мөнгөн тэмдэгтийг сайн тогтож хардаггүй. Та б үхний гарт шинэ цаасан мөнгөн тэмдэгт очвол, энэ боломжийг ашиглаад ар, өврийг нь янз бүрийн өнцгөөс сайтар ажиглаад үзээрэй.

Цаасан мөнгөн тэмдэгтийн 3 хүний талаар мэдэж авцгаая!



しぶさわえいいち 渋沢栄一 (1840-1931) бол “Японы эдийн засгийн эцэг” гэгддэг ба Мэйжи болон Тайшо үеийн бизнесмэн юм. Мэйжи үед Сангийн яамын албан хаагч байсан ба татвар, мөнгө, банк зэргийн тогтолцоо бүрдүүлэхэд хүчин зүтгэсэн. Албан хаагчаа больсны дараа Японд хамгийн эхэнд байгуулагдсан “У л с ы н 1-р банк”-наас гадна, төрөл бүрийн 500 гаруй компанийг байгуулахад оролцсон.



つだうめこ 津田梅子 (1864-1929) бол “Эмэгтэйчүүдийн боловсролын анхдагч” гэгддэг ба Мэйжи болон Тайшо үеийн эмэгтэй багш хэмээн олонд танигдсан. Эмэгтэйчүүдийн байр суурийг дээшлүүлэхийн төлөө өөрөө гадаадад суралцаж, эмэгтэйчүүдийн дээд боловсролд хүчин зүтгэсэн.



きたざとしばさぶろう 北里紫郎 (1853-1931) бол “Орчин үеийн Японы анагаах ухааны эцэг” гэгддэг ба тухайн үед хүмүүсийн айж байсан “татран” гэдэг өвчний урьдчилан сэргийлэл болон эмчилгээний аргыг нээхэд хувь нэмэр оруулж, олон хүний амийг аварсан.

Кокуго-но-мори

Энэ нь Япон хэлний үг хэллэг, ханз болон эдгээрийн хэрэглэх аргын талаар суралцахад зориулсан сурах бичиг болно. Зугаатайгаар хариуг нь бодож олцгооё. (Хариу нь дараагийн хуудсанд байгаа.)

かたかなと漢字
カタカナと漢字

円 えん

イズ

まい

ーモニカ

糸 いと

ノレール

どちらもカタカナ
どちらでもカタカナ

ニホーム

ーヒー

ロン

イフ

マラ

ー

ひらがなとカタカナ
ひらがなとカタカナ

リコプター

び

ヤンプ

つぶ

ーター

っけん

しどう 指導
もと 元
せう 世
たが 田
く 谷
りつ 立
しょう 小
がっこう 学校
じょう 教
しゅ 誦
なほし 尚
しいら 良
高橋 伶子
イラスト・奈良 恵

にている字
ちがうところをしっかりと
書き分けましょう。



Нутгийн жинжа (шинто шашны сүм)-д жил бүр болдог баярт оролцсон дадлагажигч нар. Хаппи өмсгөл өмсч, толгойндоо тууз ороон, нутгийн хүмүүстэй хамт 神輿 (микоши) өргөж үзлээ. Японы уламжлалт соёлтой танилцаж, сэтгэл хангалуун нэгэн өдөр болжээ.

※2024年9月投稿 監理団体：TNK協同組合 実習実施者：株式会社兼藤

Оролцохыг урьж байна.

Ур чадварын дадлагажигчийн хүлээн авагч байгууллагуудаас JITCO-гийн цахим хуудсанд ирүүлсэн “Ур чадварын дадлагын Days”-ээс нэг зургийг сонгон нийтэлж байна. “Ур чадварын дадлагын Days” хуудас болон зураг ирүүлэх удирдамжийг эндээс харна уу.

(<https://www.jitco.or.jp/ja/days/>)



SNS хэрэглэж эхэллээ.

Facebook болон X-ийн JITCO-гийн албан ёсны акаунт үүсгэлээ.

Facebook-ээр гадаадын хүний нөөц та бүхэнд зориулан, X-ээр гадаадын хүний нөөцийг хүлээн авч буй хүмүүст зориулан хэрэгтэй мэдээллийг түгээх болно.

Facebook-ээр Япон хэлийг оруулан 10 орны хэлээр мэдээлэл түгээнэ. Биднийг дагаж, “таалагдсан” товчлуурыг дараарай.



ひらがなも、カタカナも、もとは漢字です。ひらがなは漢字の全体をくずし、カタカナは漢字の一部を取り出して作り直しました。まちがいが多いのが、「シ」と「ツ」です。シは「之」、ツは「川」が元の字です。点の並び方の違いは、「シはたて、ツは横」と覚えてるといいですね。



ひらがな (хирагана), カタカナ (катакана)-гийн аль аль нь ханзнаас гаралтай. ひらがな нь бүтэн ханзыг задалж, カタカナ нь ханзны нэг хэсгийг нь авч бий болгосон. Их андуурагддаг нь “シ”, “ツ” хоёр. “シ” нь “之”, “ツ” нь “川”-аас гаралтай. Цэг эгнүүлэн бичих ялгаа нь, “シ” нь босоо, “ツ” нь хэвтээ” гэж цээжилбэл зүгээр.

とも

2025年1月 冬季号

2025年1月1日発行

発行

公益財団法人 国際人材協力機構 (JITCO)

総務部広報室

〒108-0023

東京都港区芝浦2-11-5 五十嵐ビルディング

03-4306-1166 (ダイヤルイン)

電話

JITCO ホームページ

<https://www.jitco.or.jp/>

Facebook

jitco.official

X

@jitco_official